

АВРАГЧДЫН СЭТГЭЛ ЗҮЙ, БИЕ БЯЛДАР, УР ЧАДВАР БЭЛТГЭЛИЙН АРГА ЗҮЙН ҮНДЭС, ТҮҮНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Л.Булганхангай

*ДХИС-ийн ОБС-ийн Гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн багш,
ахмад*

Цахим шуудан: bulgankhangai365@gmail.com

Хураангуй

Бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэл нь маш олон хүчин зүйлсээс хамааралтай, олон хэсэг бүхий нарийн төвөгтэй үйл явц юм. Эдгээр хүчин зүйл, бүрэлдхүүн хэсгүүдийг оновчтой тодорхойлох нь сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэл амжилттай болохын үндэс болж өгдөг. Аврах, гал унтраах үйл ажиллагаанд оролцож буй аврагч, гал сөнөөгчид мэргэжлийн мэдлэг ур чадвар, дадал, сахилга батыг эзэмшсэн байх нь зайлшгүй бөгөөд гамшиг осол, гал түймрийн голомтод ажиллагаа явуулах арга ухааныг эзэмшсэн, тусгай зориулалтын багаж, зэвсэглэмж техникийг хэрэглэх, ашиглах, дадлага чадвартай, байгаль цаг уур, дулааны өндөр хэм, хэт их утаажилтын бүсэд ажиллах болон үзэгдэх орчин хязгаарлагдмал зэрэг аливаа бэрхшээлийг даван туулах бие бялдарын чадвартай байх нь аврагч, гал сөнөөгчдөд өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх үндэс болно.

Сургалтын бэлтгэлийг хангах цогцолбор үйл ажиллагаанд зайлшгүй тавигдах чухал шаардлага бол сургалтын нөхцлийг аль болох бодит байдал, практик амьдралд ойртуулах явдал бөгөөд энэ нь сургалт бэлтгэлийн үед тавигдах ёстой олон шаардлагуудыг нэгэн зэрэг хангаж өгдөг. Дээрх нөхцлийг бүрдүүлсэн сургалтын нэгдсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэхгүйгээр аврагч, гал сөнөөгчдийг гамшгийн голомтод аврах, гал унтраах ажиллагаанд бэлтгэнэ гэдэг байж боломгүй асуудал юм.

Аврагч, гал сөнөөгчдөд тодорхой цочроогчийн нөлөөг үзүүлж, илрэн гарах хариу үйлдлийг шинжлэн судлах нь аврах ажиллагааны сургалтын нөхцлийг бодит орчинд ойртуулах аврагч, гал сөнөөгчдийн сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэлжилтийг хангах хамгийн үр дүнтэй хэлбэр хэмээн үзэж энэхүү сэдвээр судалгааны ажлын хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Судалгааны зорилго. Аврах үйл ажиллагаанд аврагчдын сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэлийн онол, арга зүйн үндсийг тодорхойлж, түүнд шинжилгээ хийж, тэдгээрийн мэргэжлийн бэлтгэлийн төвшинг дээшлүүлэх арга замыг тодорхойлоход оршино.

Дараах зорилтыг дэвшүүлэв. Үүнд:

-Аврагчдын сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэлийг тодорхойлох онол, арга зүйн үндсийг гаргах;

-Аврагчдын сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэлд шинжилгээ хийх;

-Аврагчдын сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэлийг тодорхойлох;

-Аврагчдын сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэлийг дээшлүүлэх арга замуудыг тодорхойлох.

Судлах зүйл. Аврагч гал сөнөөгчдийн сэтгэл зүй, бие бялдар, мэргэжлийн ур чадварын бэлтгэлжилт, түүний аврах үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллүүд

Судалгааны ажлын хязгаарлалт. Аврах, гал унтраах ангийн аврагч, гал сөнөөгчид

Судалгааны арга. Энэхүү судалгааны ажилд ажиглалт, харьцуулалт хийж, задлан шинжилж, нэгтгэн дүгнэх, онцгой байдлын албаны бие бүрэлдэхүүний багаж зэвсэглэмжтэй харьцах норматив хугацаа, сургалтын аргуудыг хэрэглэнэ. Мөн гадаадын болон өөрийн орны эрдэмтэн судлаачдын эрхлэн гаргасан ном, товхимол, өгүүлэл, нийтлэл, норматив зэргийг онол арга зүйн хэрэглүүр болгон ашигласан болно.

Объектын болон ой хээрийн гал түймрийн аюулыг бууруулах, нэгэнт гарсан гал түймрийг хохирол багатай унтраахад аврагч гал сөнөөгчдийн сэтгэл зүй, бие бялдар, мэргэжлийн ур чадварын бэлтгэл нь харилцан хамааралтай болохыг судлах бөгөөд сургалт, дасгалжуулалтын хөтөлбөр, заавар боловсруулахад саналаа тусгах.

Судалгааны ажлын практик ач холбогдол. Аврах үйл ажиллагаанд аврагчдын сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэлийн арга зүйн үндсийг тодорхойлон, түүнд шинжилгээ хийж, тэдгээрийн мэргэжлийн бэлтгэлийн төвшинг дээшлүүлэх арга зам тодорхойлж цаашид боловсронгуй болгох шинэлэг санал дэвшүүлсэн нь практикийн ач холбогдолтой юм.

Бидний судалгааны ажлын үр дүнд гал унтраах үйл ажиллагааны үед аврагч, гал сөнөөгчдийн мэргэжлийн ур чадварын ялгааг сургалтын ямар арга хэлбэрээр ойртуулж болох, аврагчдын сэтгэл зүй, бие бялдарыг хөгжүүлснээр багаар ажиллах ажиллагаанд хэрхэн нөлөөлөх, орчин үеийн техникийн дэвшил ашиглан зохион бүтээгдсэн аврах гал унтраах багаж зэвсэглэмжээр ажиллах ур чадварыг, аврагч, гал сөнөөгчдийн сэтгэл зүй бие бялдарын бэлтгэлтэй хэрхэн уялдуулах зэрэг хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Энэ ажлын хүрээнд манай улсын болон гадаадын улс орнуудын эрдэмтэн судлаачдын ном зохиолыг харьцуулан судалж аврагч, гал

сөнөөгчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд, сэтгэл зүй, бие бялдарын сургалттай хослуулан зохион байгуулах, онолын болон практик үйл ажиллагаанд тулгуурлан санаа, сэдлээ гаргасанд судалгааны ажлын ач холбогдол оршино.

Судалгааны ажлын үр дүн. Уг судалгааны ажлын үр дүн нь Онцгой байдлын байгууллагын аврах, гал унтраах ангийн аврагч, гал сөнөөгчдийн сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсүүдийн талаар нэгдсэн ойлголттой болоход чухал үүрэг гүйцэтгэнэ. Нөгөө талаас судалгааны ажил нь энэ сэдвээр судалгаа шинжилгээний ажил хийх болон сонсогч оюутнуудад сургалтын материал хэлбэрээр ашиглах боломжтой.

Дэвшүүлж буй асуудлууд. Судалгааны ажлын хүрээнд дараах асуудлуудыг дэвшүүлж байна:

- Аврагчдын сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэлд хийсэн шинжилгээний үр дүн;
- Аврагчдын сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэл аврах үйл ажиллагаанд нөлөөлөх байдлыг тодорхойлсон дүн
- Аврагчдын оюун ухаан, сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэлийг дээшлүүлэх арга зам

Аврагчдын сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэлийг тодорхойлох онол, арга зүйн үндэс

Гамшиг, ослын аюулаас иргэдээ хамгаалах гол арга хэлбэр бол аврагч нарыг болон иргэдийг аврах үйл ажиллагаанд сургасан байх явдал юм. Чухам юунд сургах ёстойг аврах ажиллагаанд оролцсон туршлага, сургамжаар тодотгож, сургалтын онол, практик тодорхойлж өгдөг. Тийм ч учраас аврагч нарын үндсэн хөдөлмөр бол аврах ажиллагаанд суралцах явдал гэж томъёолж болно.

Орчин үеийн сургалтад баримталж буй боловсролын философи хандлага, үзэл баримтлал, онол арга зүйн асуудлыг товч авч үзье.

Орчин үеийн өрнөдийн философи дахь олон урсгал чиглэлийн нэг бол фрейдизм. Энэ философи дэлхийн хэмжээнд тухайн үедээ төдийгүй одоо ч нэр нөлөөтэй хэвээр байна. Фрейдизмыг үндэслэгч нь Австрийн философич Зигмунд Фрейд юм. Фрейд 1856 онд Чехийн Фрейбург хотод төрсөн. Венийн Их сургуульд суралцсан ба хожим дэлхийд алдартай сэтгэл зүйч, философич, мэдрэлийн эмч, багш, социологич болжээ.

Фрейдийг өрнөдийн орнуудад сүүлийн хоёр зуунд төрсөн хоёр суу билигтний нэг хэмээн үздэг. Нөгөө нь К.Маркс ажээ. Фрейдизм бол хүний тухай философи юм. Фрейдийн үзсэнээр бол хүний оюун санаа эго, супер

эго, ид гурваас бүрддэг²⁸. Эго бол хувийн ухамсар гэж хэлж болох тэр зүйл. Үүнийг хүн амьдрах орчин нөхцөлөөсөө олж авна.

Супер эго нь нийгэмд амьдарч байгаа хүмүүст нэгэн утгаар ойлгогддог тэр зүйл бөгөөд бидний нэрлэж заншсанаар бол нийгмийн ухамсар гэдэгтэй утга ойролцоо юм. Ид нь ухамсарлагдаагүй оюун санаа бөгөөд хүнд төрөлхөөс байдаг тэр зүйл өөрөөр хэлбэл тухайн хүний зан төлөв, төрөлх авьяас гэдгээр ойлгож болно. Хүний боловсрол, соёл нэмэгдэх тутам эго, супер эго илт давамгайлах хандлагатай болдог. Ямар ч хүн ямар нэг муу юм хийхэд бэлэн байдаг. Гэвч энэ бүх сэдэл, тэмүүлэл нь нийгмийн ёс суртахуун, соёл иргэншилд дарамтлагдаж, хүн биеэ барьсан байдалтай болдог гэж Фрейд үзжээ.

Фрейдизм хүүхдийн зан төлөв, төрх байдлыг төлөвшүүлэхэд психоанализ /сэтгэцийн шинжилгээ/ чухал үүрэгтэй гэж үздэг. Орчин үеийн сургалтад Фрейдизмын үзэл онолыг нэвтрүүлж суралцагчдын авьяас сонирхол, хэрэгцээг харгалзан үзэх, хүүхэд бүрийг шинжин таньж, тэдний онцлогт нь тохируулан сургах шаардлага нэн чухлаар тавигдаж байна.

Монгол ардын сурган хүмүүжүүлэх ухаанд хүн бүр оюун ухааны өөрийн гэсэн “сав”-тай байдаг. Тэр “сав”-ных нь хэмжээнд тааруулан сургаваас зохилтой хэмээн үздэг билээ. Сэтгэл судлаачид танин мэдэх үйл ажиллагааг нарийвчлан судалсны үндсэн дээр мэдлэг эзэмших явцад нөлөөлдөг сэтгэл зүйн бүтцийг олж тогтоожээ. Мэдлэг эзэмших явцыг туршилтаар судлан орчин үеийн Сурган хүмүүжүүлэх ухаанд томоохон хувь нэмэр оруулсан онолын нэг нь Америкийн Нэгдсэн Улсад ХХ зууны эхээр үүссэн бихевиоризм юм.

Бихевиористууд “Хүнийг бүхий л зүйлд сургаж болно. Гагцхүү гаднаас үзүүлэх цочроогчийг зөв хослуулан өгөх замаар хүссэн хариу үйлдлийг хүлээж болно” гэж үздэг. Гол үндэслэгч нь Б.Оотсун “Надад дөнгөж төрсөн 10 нярай хүүхэд өгөөч. Тэгвэл би тэднийг эмч, багш, хуульч, тэрч байтугай хулгайч дээрэмчин болгож чадна”²⁹ гэжээ.

Бихевиористууд “Программчилсан сургалт”-ын эх үндсийг тавьсан бөгөөд К.Холл, Э.Толмва нар сурах үйл явцыг туршилтаар судлан мэдлэг эзэмших 3 хуулийг томъёолжээ. Үүнд: Судалж буй материалыг дахин дахин давтах дасгалын хууль. Орчин үед хичээлийг “Нэгжийг томсгосон бүлэглэх арга”-аар зохион байгуулж, шинэ мэдлэгийг багцалж цөөн цагт багтаан багш, суралцагч хоёр хамтран “бүтээсэн”-ий дараа мэдлэгээ практик хэрэглээ болгож бататган давтах дасгал ажлыг олон дахин давтан хийхийг чухалчилж буй нь энэхүү дасгалын хуулийг хэрэгжүүлж буй хэрэг юм.

²⁸ Чөлөөт нэвтэрхий толь — Википедиагаас

²⁹ Чөлөөт нэвтэрхий толь — Википедиагаас

Эерэг үр дүнгийн хууль. /сэтгэл ханамж авах/ Багш нар “Сургалтын хөтөлбөр”-ийг чанартай боловсруулснаар нэгж хичээлийн бэлтгэл, зохион байгуулалт, агуулга, арга зүй төгөлдөржиж, ингэснээр эерэг үр дүнд хүрч суралцагчид сэтгэл ханамжтай байх болно. Зөв шийдвэрийг байнга давтах бататгалын хууль. Сэтгэл судлаачдын судалснаар “Багш нар өнөөдрийн шинэ мэдлэг мэдээллийг үндсэндээ 90- 100 хувь олгож чадаж байгаа ажээ. Харин тодорхой хугацааны дараа дахин бататган давтахгүй бол марталт бий болж, өнөөх 100 хувь нь 50, 60 хувь, магадгүй түүнээс ч доош болдог байна. Чухам энэ үед дахин бататгаж сэргээн сануулах шаардлагатай. Үүний дараа мөн л тодорхой хугацааны дараа бататган давтахгүй бол дахин мартаж 100 хувь нь 70, 80 хувь болсон байна. Энэ үед дахин бататгаж сэргээн сануулах хэрэгтэй. 2 дах удаад марталтын хувь зохих хэмжээгээр багасч буй нь дахин бататган давтсаных юм. Ийнхүү шинэ мэдлэгийг дунджаар 6-8 удаа бататган давтах шаардлагатай бөгөөд ингэснээр суралцагчдын мэдлэг, чадвар гүн бат болно гэж үзэж байна.

Уламжлалт сургалтын үед 10 цагийн бүлэг сэдвийг заахдаа 1 цаг бүр дээр шинэ мэдлэг олгох, бататган давтах, дасгал ажиллах, дүгнэх үйл ажиллагааг салангид явуулдаг байсан учир 10 цагийн бүлэг сэдэв үзэж дууссаны дараа сурагчид өмнөхөө мартаж, сүүлийн 2-3 цагийн хичээлийг сэргээн санах хэмжээнд хүрч, чадвар дадал болж чаддаггүй байжээ.

Орчин үед дээрх 10 цагийн бүлэг сэдвийн 2 цагт нь шинэ мэдлэгээ багш, суралцагч хоёр хамтран бүтээгээд 6 цагт нь бататган давтаж чадвар дадал болгох, 1 цагт мэдлэгээ системчлэн нэгтгэн дүгнэж хийсвэрлэх, үлдсэн 1 цагт юу мэдэж, чаддаг болсноо өөрийн болон хөндлөнгийн үнэлгээгээр илрүүлж ололтоо бататгаж, дутагдлаа засч ажиллах нь *бататгалын хуулийг* хэрэгжүүлж буй хэрэг юм.

Орчин үеийн боловсролын философид “Конструктив” онол үзэл тэргүүлэх байр суурьтай байна. “Конструкция” хэмээх нь байгуулах, бүтээх гэсэн утгатай латин үгнээс гаралтай. Гол төлөөлөгчид нь Ж.Пиаже, Л.С.Выготский, А.Бангдург нар юм.

Хүний хөгжилд түүний өөрийнх нь идэвхтэй үйл ажиллагаа хамгаас чухал. Хүний оюун ухаанд өөр хөндлөнгийн хүн мэдлэг бүтээж чаддаггүй. Гагцхүү тэр хүн өөрөө л өөрийнхөө итгэл үнэмшлийг бий болгох боломжтой. Ингэж өөрийнхөө оюун ухаанд өөрөө итгэл үнэмшил буй болгож, мэдлэг бүтээж сурснаараа өөрөө өөрийгөө өөрчлөх, улмаар хөгжих, боловсрох чадвартай болно.

Нийгмийн хөгжил, хүний хөгжил ер аливаа хөгжил хүний идэвхтэй үйл ажиллагаанаас шалтгаалдаг. Ийм учраас багш - суралцагч хоёрын хамтын идэвхтэй үйл ажиллагааны явцад мэдлэг бүтнэ. Энэ утгаараа багш бол сургалтын менежер байдаг учраас менежментийн арга ухаанд үндэслэн үйл ажиллагаагаа явуулна гэсэн үг. Хүний үйл ажиллагааны онцлог нь удирдан зохицуулагдах шинж чанар юм. Үүгээрээ адгуусны зөн

бэлгээс ялгагддаг. Нийгмийн хөдөлмөрийн хуваарийн үр дүнд менежмент хэмээх хүмүүсийн үйл ажиллагааны биеэ даасан төрөл гарч ирсэн.³⁰ Өөрөөр хэлбэл хүмүүсийн урт удаан хугацааны хүчин чармайлтын үр дүнд байгууллагыг удирдах үйл ажиллагаа нь биеэ даасан төрөл болон хувирчээ.

Удирдах ажлыг эрхлэн явуулах үндэс болох хүний мэдлэгийн цогцыг менежмент гэдэг. Ийм мэргэжлийг эзэмшсэн хүмүүсийг менежер гэнэ. Менежер нь тухайн байгууллагын бүх талын үйл ажиллагааг удирдан чиглүүлэгч хүн юм. Менежерийн ур чадвар, мэдлэг боловсрол, дадлага туршлагаас тухайн байгууллагын амжилт ололт, удаан оршин тогтнох чадвар ихээхэн шалтгаална.

Менежер хүн тодорхой ур чадварыг эзэмших шаардлагатай. Ур чадвар гэдэг нь мэдлэг, мэдээлэл, дадлага туршлага тодорхой байр суурь дээр тулгуурлан үр дүнд хүрэх чадавх юм. Ур чадвар бол зөвхөн онолын мэдлэгээ практикт хэрэгжүүлэх үйл ажиллагаа биш, энэ нь олон зүйлийн үр дүнд бүрдэж буй болдог. Менежерийн ур чадвар нь хувь хүний өөрийн зан төрхөөс их шалтгаална. Менежментийн ухааныг ерөнхийд нь техникийн, харилцааны, шийдвэр гаргах чадвар гэж хуваан үздэг.

Техникийн ур чадвар – Ноогдсон үүрэг даалгаврыг тодорхой арга барилаар эрхлэн гүйцэтгэх ур дүй, дадлага, мэргэжлийн чадварын цогц юм. Менежер хүн өдөр тутмын ажлаа амжилттай гүйцэтгэхийн тулд техникийн ур чадвараа ямагт хөгжүүлэх шаардлагатай байдаг.

Харилцааны ур чадвар – Хүнтэй ажиллах, тэдгээрийг зөв ойлгох, нөлөөлөх, тэдгээртэй нийцэн ажиллах ур дүйг хэлнэ. Менежерүүд түүний дотор багш нар ажлынхаа ихэнх цагийг хүнтэй ажиллахад зарцуулдаг. Тэд хамт олон, хувь хүнтэй хамтран ажиллахдаа тэднийг идэвхжүүлэх, манлайлах, тэдэнд нөлөөлөх ур чадварыг зайлшгүй эзэмших шаардлагатай. Түүнчлэн хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулахад бичих, ярих, унших, сонсох чадвар нэгэн адил чухал ач холбогдолтой юм.

Шийдвэр гаргах чадвар – Ерөнхий онол, хийсвэр санааг тодорхой нөхцөл байдалд тохируулан хэрэглэх үр дүнг хэлнэ. Асуудлын хамрах хүрээ, түүнд нөлөөлж буй хүчин зүйл, онцлог, байгууллагын үр ашигт нөлөөлөх хэм хэмжээ зэргийг сайтар харгалзан үзэж бодит байдлыг зөв таньж, мэдэж байж оновчтой шийдвэр гаргана. Менежер хүн зөв шийдвэр гаргах чадвар эзэмшихийн тулд асуудлыг шийдэх сонголтын олон хувилбар тус бүрийг үнэлэх, дүгнэх, тооцох улмаар сонголт бүрийн үр дагаврыг урьдчилан харах чадвартай байх нь чухал юм.

Нүүдэлчин монголчуудын сурган хүмүүжүүлэх сэтгэлгээг авч үзье.

³⁰ О.Үржин, П.Цэдэв. Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ. судалгааны ажил. УБ., 2013

Монгол нутагт 750 мянган жилийн өмнөөс хүн амьдарч ирснийг түүхчид нэгэнт тогтоожээ. Монголчууд бол Төв Ази дах байгаль экологийн өвөрмөц онцлогтой, өрнө-дорнын соёл иргэншлийн хүчтэй нөлөө бүхий, байгаль-хүн-мал гурвын зохистой хослолыг илэрхийлсэн, нүүдлийн соёл иргэншлийг цогцоор нь хөгжүүлж, хадгалсан үндэстэн юм. Манай өвөг дээдэс нүүдэллэн аж төрсөн олон мянган жилийн түүхэн явцдаа эдийн болон оюуны соёлын арвин их өвийг уламжлан хөгжүүлж иржээ.

Монгол гэр, монгол хувцас, монгол цагаан идээ, монгол мал аж ахуйн тоног хэрэгсэл, монгол хоол хүнс түүнийг хадгалах, боловсруулах арга технологи, таван хошуу мал тэдгээрийг адгуулах арга технологи зэрэг хүмүүн төрөлхтөнд нэн ховор эдийн соёл, байгаль дэлхийгээ шүтэн дээдлэх, хайрлан хамгаалах, хүн-байгаль-малын тэнцвэрт экологийг хадгалсан монгол ухаан, хот айл-саахалтаар аж төрөх, хөдөлмөрлөх хамтач нийтэч үзэл, ахмад үе- настнаа хүндлэн дээдлэх, ахачлах дүүчлэх ёс, монгол хүний гоо сайхны үнэт зүйл-эрдэм номыг эрхэмлэн дээдлэх ёс суртахуун, монгол бичиг, ертөнцийн гурав, ургын бичиг хөтлөх зэрэг оюуны арвин их соёлыг хойч үедээ уламжлуулан үлдээжээ. Энэ бүхэн нь монгол хүн бүрийн эзэмших мэдлэг, сурах чадварын цогцолбор бөгөөд өнөөгийн монгол хүний боловсролын агуулгын цөм нь байх ёстой юм.

Сургалтын сэтгэл зүйн үндсийг зөв тодорхойлох нь боловсролын бодлогод нөлөөлөх чухал асуудлын нэг билээ. Сэтгэл зүйн онол бүр нь хүний хөгжлийг аль нэг талаас нь авч үздэгээрээ онцлог юм. Тухайлбал, Ж.Пиажегийн “Конструктив онол”, Х.Герднарын “Оюун ухааны цогцолбор онол”, Э.Эриксоны “Би” сэтгэл судлал зэрэг хүний хөгжлийг өөр өөрийн үзэл хандлагаар тайлбарласан олон онолууд гарчээ. Эдгээрийн үзэл санааг сургалтын хөтөлбөр боловсруулахдаа тусгах шаардлагатай. Сургалтын сэтгэл зүйн үндсийг бүрдүүлэгч гол гол онолуудаас товч авч үзвэл Ж.Пиажегийн “Оюун ухааны хөгжлийн тухай” онол байна. Энэ нь мэдлэгийг бүтээлчээр эзэмших замаар хувь хүний дасан зохицох үйл явцыг сайжруулахад чиглэгдэх бөгөөд сургалтын хөтөлбөрийн хамрах хүрээ, судлагдахууныг тодорхойлохдоо:

- Хүүхдийн оюун санааны хөгжлийн үе шат, боломжид тулгуурлах;

- Суралцагчдын хийсвэр сэтгэлгээний онцлогт тулгуурлаж, үйлдлийн тогтолцоог эзэмшүүлэх, мэдлэг бүтээх, мэдлэгийн бүтцийг интеграцичлах аргуудаар хэрэгжүүлдэг байна.

Л.С.Выготскийн “Сургалт ба хөгжлийн харьцааны тухай” онол нь суралцах болон оюуны үйлийн баримжааллыг зөв тодорхойлоход чиглэгдэх бөгөөд сургалтын хөтөлбөрийн хамрах хүрээ, судлагдахууныг тодорхойлохдоо суралцагчийн оюуны үйлийн “ойрын бүс” буюу өнөөдөр хараахан хийж чадахгүй байгаа боловч маргааш хийж чадах зүйлд

тулгуурлаж, оюуны үйлийг шатлан төлөвшүүлэх аргаар хэрэгждэг байна. Чухам Л.С.Выготскийн “Сургалт хөгжлийг ямагт араасаа дагуулна”³¹ гэсэн тодорхойлолт нь өнөөдөрч өндөр үнэ цэнтэй хэвээр байж онол аргазүйн үндэс болсоор байна.

Сургалтын технологи нь. Сурах сургах үйл ажиллагааны тодорхой зорилгоос түүний үр дүн хүртэлх өргөн хүрээтэй ойлголт юм. Сургалт гэдэг ухагдахууны талаар эрдэмтэн судлаачдын олон тодорхойлолт байдаг. Тухайлбал:

Сургалт бол нийгэм түүхийн туршлагыг хойч үедээ дамжуулах үйл буюу тодорхой тогтолцоо бүхий мэдлэг, чадвар, дадал төлөвшүүлэх явц.³²

Сургалт нь тодорхой тогтолцоо бүхий мэдлэг, чадвар, дадал төлөвшүүлж, боловсрол олгох, дамжуулах үйл ажиллагаа, төлөвлөгдсөн үйл явц, арга хэрэгсэл, тогтолцоо, чанарын өөрчлөлт хийх хэрэгсэл бас орчин бөгөөд тодорхой зорилгод хүрэхийн тулд хийж буй багш шавь хоёрын идэвхитэй хамтын үйл ажиллагаа бие даасан ухамсартай хандлага³³ юм.

Сургалт бол багшийн сургах, шавийн сурч танин мэдэх үйл ажиллагааны нэгдэл, амьдрал, үйл ажиллагааны орчин үеийн шаардлагад нийцүүлэн амьдрах ухаан, нийгмийн туршлагыг ахмад үеэс хойч үедээ системтэй дэс дараатай, зорилго чиглэлтэйгээр зохион байгуулалттайгаар дамжуулан өвлүүлэхэд чиглэсэн зорилго, агуулга, зарчим, арга хэлбэр, хэрэгсэл гэсэн үндсэн бүтэц бүхий тасралтгүй хөгжих үйл явц юм. Сургалт нь бие хүнийг төлөвшүүлэх, боловсрол олгох зорилго агуулгыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн багш суралцагсадын хамтын үйл ажиллагааны эрэмбэлэгдсэн үйлдэлүүдийн нэгдэл³⁴

Сургалт бол хүнийг бие хүн болон төлөвших, мэдлэг, дадлага туршлага хуримтлуулж боловсрох, амьдрахад ач холбогдол бүхий нийгмийн үзэгдэл юм. Сургалт бол бие хүнийг төлөвшүүлэх, хөгжүүлэх ажлын гол цөм, боловсролыг эзэмших үндсэн зам буюу арга хэрэгсэл³⁵ гэж тодорхойдсон байна.

³¹ Л.С.Выготскийн., Сургалт ба хөгжлийн харьцааны тухай, 2006

³² Д.Ванчигсүрэ., Б.Энхтүвшин., Боловсрол судлалын ухагдахууны товч тайлбар толь, УБ.,1994

³³ Г.Эрдэнэ-Очир., Ерөнхий дидактикийн үндэс, УБ.,1995

³⁴ Боловсрол судлалын ерөнхий үндэс, УБ., 1997

³⁵ Б.Бор., Сурган хүмүүжүүлэх зүй, УБ.,1970

Технологи гэсэн үг нь *Techne*- урлан, дархан, шинжлэх ухаан *Logos* ойлголт ухаан гэсэн Грек үгнээс гаралтай үйлдвэрлэлийн арга хэрэгсэлийн нэгдлийг тодорхойлсон цогц мэдлэг. Сургах үйл ажиллагааны хамгийн оновчтой түгээмэл үр бүтээлтэй дэс дараалал буюу алгоритм юм гэж тайлбар хийсэн байдаг.

Орчин үеийн сургалтын технологийн мөн чанар нь сургалтын дэвшүүлсэн зорилгод хүрэхийн тулд удирдлагаар хангагдан зохион байгуулагдсан сургалтын үйл явц гэж тодорхойлж болно. Өөрөөр хэлбэл шинжлэх ухааны үндэслэлтэй, хэрэглээтэй чиглэсэн зорилготой дидактик үйл явц бөгөөд шижлэх ухааны хандлага багшийн идэвхи санаачлага амьдралын туршлагад тулгуурлан зохион багуулагдах үйл явц ба суралцагсадыг бие хүн болон төлөвшүүлэхэд өндөр үр дүнд хүрэхэд чиглэгдэнэ.

Ийм системийн бүтцийг авч үзвэл сургалтын зорилго, агуулга, багшийн хэрэгсэл ба сэдэлжүүлэх харилцан үйлчлэх сурган хүмүүжүүлэх хэрэглэгдэхүүн, сургалтын үйл явцыг зохион байгуулах, суралцагсад, багшийн үйл ажиллагааны үр дүн эдгээр болно. Ийм байдлаар сургалтын технологийг төсөөлбөл сургалтын үйл явцыг удирдах нь харилцан холбоотой хоёр үйл ажиллагаанаас тогтож байна. Үүнд: Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах ба энэ үйл ажиллагааг хянах явдал юм. Энэ үйл явц нь тасралтгүй харилцан үйлчилнэ. Хяналт нь удирдлагын үйл ажиллагааны агуулгад нөлөөлдөг өөрөөр хэлбэл цаашдын үйл ажиллагааг өөрчлөн зохион байгуулахад туслана.

Сургалтын технологийн үндсэн зарчимууд: Сургалтын технологи нь өөрийн гэсэн дараах зарчимтай байдаг. Тухайлбал

- Нэгдмэл байх зарчим: өөрөөр хэлбэл сургах, хүмүүжүүлэх, хөгжүүлэх үйл явц нь нэгдмэл байдлаар системтэй хэрэгжинэ.

- Суурилах зарчим: сургалтын агуулгын тодорхой хэсэг нь суурь болох бөгөөд үүн дээр бусад хичээлүүдийг оновчтой байрлуулах нь чухал байдаг. Түүнчлэн тухайн хичээл бүрийн агуулга, суурь мэдээлэлтэй байна. Суурийг оновчтой тодорхойлох нь сургалтын үр дүнг дээшлүүлэхэд тэргүүлэх ач холбогдолтой.

- Сургах явцдаа судлах, судлах явцдаа сургах зарчим: сургахын зэрэгцээ багш бүр тодорхой шинжлэх ухааны чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх шаардлагатай бөгөөд суралцагчдыг ч энэ талаар сургаж дадлагажуулах нь орчин үеийн шаардлага болж байна. Тухайн шинжлэх ухааны сургалтын агуулгыг гүнзгийрүүлэн судалж хэрхэн эзэмшүүлэх арга зүйг байнга боловсронгуй болгож байх хоёр талт үйл явцыг тодорхойлдог.

- Боловсролын тасралтгүй байх зарчим: хүнийг насан туршид нь сургана гэж үгүй. Түүнээс гадна мэдээллийн шинэчлэл эрчимжсээр байна. Иймд сургалтын явцад суралцагчдыг “ Суралцахад сургах” сургалтын бие даасан хэлбэрт шилжүүлэх зарчмыг баримтлан ажиллах.

- Суралцагчдыг үйл ажиллагааны явцад сургах зарчим: Орчин үед суралцагчдыг тодорхой үйл ажиллагаанд татан оролцуулах нөхцөлийг бүрдүүлэх, энэ нөхцөлд тэд шинэ мэдлэг, чадвар, ухааныг олж эзэмших технологийг сонгон хэрэгжүүлэх.

Сургалтыг оновчтой болгох: Сургалтын явцад олон янзын хувилбартай болгох, загварчлах эрчимжүүлэх, боловсронгуй болгох үр ашгийг нэмэгдүүлэх, бодит үр дүнд хүрэх гэсэн сургалтын оновчтой хэлбэрүүд байдаг. Эдгээрийг тайлбарлавал:

-Бодит үр дүн - хүлээгдэж буй хамгийн өндөр үр бүтээл

-Сургалтыг олон янзын хувилбартай болгох – сургалтын бүтцийг өргөжүүлэн, зохион байгуулалтыг тохиромжтой болгох үйл явц

-Сургалтыг загварчлах – сургалтын агуулга, арга хэлбэрийг шинэчилж орчин үеийн шаардлагад тохируулах үйл явц

-Сургалтыг боловсронгуй болгох – олон янзын хувилбартай болгох, загварчлах үйл явцуудын үр дүнд тухайн нөхцөлд, эсвэл сонгон авсан эсэхэд илүү дэвшилттэй байх үйл явц

-Сургалтын үр ашгийг нэмэгдүүлэх – ямар арга замаар тухайн үр дүнд хүрэх гэдгээр шалтгаалахгүйгээр эцсийн үр дүн дээшилж буй үйл явц

-Сургалтыг оновчтой болгох – хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнд хүрэх үйл явц

Тухайн нөхцөл байдалд хүрч болох хамгийн өндөр үр дүн элдэв ачааллыг үгүй болгож тодорхой норматив цаг хугацаа зарцуулсан байх, тавьсан зорилгод дээд зэргээр тохирсон байх ёстой гэж үздэг байна. Ямар нэг үйл явцыг оновчтой болгоход дараах гурван зарчмыг баримтлана. Үүнд:

-Системтэй байдал – тухайн үйл явцын дотоод, гадаад элементүүдийг боловсронгуй болгох хоорондын холбоо уялдааг бэхжүүлэх

-Тодорхой байдал – тухайн нөхцөлд тавьсан зорилгодоо хүрэх хамгийн үр ашигтай үйл ажиллагаа

-Хэм хэмжээг сахих байдал – системийн нэг хэсгийг хэтэрхий ихэсгэснээс нөгөө хэсгийн үйл ажиллагаа саатуулж болно. Ийм нөхцөл байдалд тохирсон арга хэмжээг авч явуулах шаардлагатай болно.

Мэргэжлийн сургалт бэлтгэлийн онцлог. Гамшгаас хамгаалах сургалтын зорилт нь гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд байгууллага, алба, албан тушаалтан, иргэдийг сургаж, дадлагажуулахад

оршино.³⁶ Гал түймэр унтраах үйл ажиллагааг зохион байгуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангах ажлын үндсэн хэсэг нь дадлага сургалтын ажил мөн³⁷ гэсэн нь гал түймрийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх авран хамгаалах, унтраах үйл ажиллагаа явуулах нь онцгой байдлын байгууллагын чиг үүрэг бүхий алба хаагч бүрийн үүрэг юм. Алба хаагч нь өргөсөн тангарагтаа үнэнч байж, гал түймэр унтраах үйл ажиллагааг өмчийн харъяалал харгалзахгүй сэтгэл зүй, бие бялдар, мэргэжлийн ур чадвараа бүрэн дайчлан тэсвэр хатуужил, авхаалж самбаа, санаачлага гарган ямар ч үед бэрхшээлийг даван туулж, өгөгдсөн үүргийг биелүүлэх үүрэгтэй.

Аврагч, гал сөнөөгч нэг бүрт эр зориг, тэвчээр хатуужил, санаачлага, цагийн байдалд үнэлгээ өгч богино хугацаанд шийдвэр гарган авхаалж самбаа, нягт нямбай, шуурхай хамтач үйл ажиллагаа явуулах, харилцан бие биенээ ойлгох, туслах аврах, гал унтраах үйл ажиллагаанд бодит дүгнэлт хийж ашигтай хувилбарыг сонгон авах чадварыг эзэмшүүлэх. Алба хаагч нэг бүрт албаны үүргээ биелүүлэх хариуцлагыг ухамсарлуулах, гал унтраах техник хэрэгсэл, багаж зэвсэглэмжийн найдвартай ажиллагааг хангаж өөрийнхөө болон баг хамт олныхоо хүчинд бүрэн итгэх итгэлтэй болгон сургаж дадлагжуулах нь зайлшгүй шаардлагатай байдаг.

Тухайлбал, ямар арга, хэлбэрээр хүнийг сургах талаар У Цзы номлохдоо, “Нэг хүн сурснаар арвыг сургана, арав дайтаж сурснаар зууг сургана гэх мэт”³⁸ гэсэн номлол нь хүн нэг бүрийн бэлтгэлээс хэсэг, тасаг, салаа, ангийн дотоод үйл ажиллагааг хангах сургалтын нэг чухал хэлбэрийг тодорхойлсон хэрэг гэж үзэж болно. Дайн байлдааны ажиллагаа явуулахад бэлэн болгохын тулд ард иргэд, цэрэг дайчдаа сургаж бэлтгэх асуудал нь урт удаан хугацаа шаарддаг бөгөөд нарийн арга ухаанд тулгуурладаг байжээ. Тухайлбал, Их засаг хуульд “жанжин захирагчаас жирийн цэрэг хүртэл дайсангүй ч дайны бэлтгэл хийх”³⁹ гэж заасан нь сургалт бэлтгэлийг хэдий сайн хийнэ төдий чинээ ялалт авчрах боломжтойг харуулж байна.

Зарим онолчид өнгөрсөн үеийнхээ ололт, амжилтын үндэс, туршлагыг судлан бүтээл туурвилаа гарган “аюулаас” аврах арга замыг хайжээ. Ф.Р.Вегеций сургалтын талаар өнөө үеийнхэн хүртэл санууштай, бас шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлэлт, дүгнэлтийг хийжээ. Тухайлбал: “Урт удаан хугацаагаар ... алба хааснаар цэргийн хэргийн мэдлэгийг бүрэн эзэмшихгүй, гагцхүү дасгал, сургуулилтыг тасралтгүй хийснээр бүхий л

³⁶ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7.1-д

³⁷ Гал түймэр унтраах дүрмийн хоёрдугаар бүлгийн 5-д

³⁸ Г.Соронзонболд., П.Цэдэв., Аврагчдын сургалтын мөн чанар, тогтолцоог боловсронгуй болгох арга зам, УБ., 2013

³⁹ Мөн тэнд, х7

урлагийг эзэмшиж чадна. Иймээс өдөр бүр, цаг тутам дасгал дадлага хийвэл зохино. Эцсийн эцэст бэлтгэгдэж сургагдсан нь ялахаас биш, хэн эр чадалтай нь ялахгүй гэдгийг мэдэж авах хэрэгтэй. Зэвсгээ ашиглах урлагийг эзэмшээгүй цэрэг нь ердийн ардтай адилхан тул тийм цэргийг цэрэг гэхгүй”⁴⁰ гэж дүгнэсэн нь сургалтын ач холбогдолыг харуулж байна.

Аврах, гал унтраах үйл ажиллагааны техник хэрэгсэл, багаж зэвсэглэмж боловсронгуй болохын хэрээр түүнийг эзэмших, ашиглах, сурах ажиллагаанд онолын мэдлэгээс гадна практик дасгал, дадлага, ур чадварын ач холбогдол чухлаар шаардагдах боллоо. Чухамхүү аврах үйл ажиллагааны сургалтын онол, практикийн нэгдлийг хангах нь аврагчдын чадварыг дээшлүүлэх чухал хэлбэр болон хувирч байна. Онцгой байдлын байгууллагын хэмжээнд үүрэг гүйцэтгэж байгаа нийт төрөл мэргэжлийн аврагчдын 80 орчим хувийг эзэлж байгаа аврагч, гал сөнөөгчдийн сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын сургалтыг хэрхэн яаж бэлтгэх вэ гэсэн асуулт зүй ёсоор оршин байсаар байна.

Тэгвэл аврах ажиллагаа гэж гамшгийн аюулын үед хүн, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйлийг эрж хайх, аврах, гал түймрийн шаталтыг зогсоох, унтраах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх, хор уршгийг арилгах үйл ажиллагаа⁴¹ гэж тодорхойлсон байдаг. Аврах үйл ажиллагааг явуулахын тулд аврагчдад тусгайлсан бэлтгэл сургалтыг системтэй зохион байгуулах нь эрсдлийг бууруулах чухал ач холбогдолтой юм. Сургалтын тусламжтайгаар бие хүн боловсрол эзэмшиж, бие даан нийгмийн дунд ажиллаж амьдрахад шаардагдах мэдлэг, чадвар, дадал, амьдрах ухаан, туршлага хандлагыг өөртөө төлөвшүүлдэг. Боловсрол эзэмших үндсэн арга зам нь суралцахуй бөгөөд түүний удирдлага зохион байгуулалттай хэлбэр нь бэлтгэл сургалт билээ. Харин “**бэлтгэл**” гэдэг үгийг монгол хэлний тайлбар тольд бэлдвэр; урьдчилан бэлдсэн юм; бэлэн болгож зэхэх;⁴² гэж тайлбарлажээ. Аврагчдын сургалтыг өнөө үед аврах үйл ажиллагааны сургалт бэлтгэл гэсэн цогц ойлголтоор авч үзэж байна. Аврагчдын сургалтын мөн чанарыг тодорхойлохын тулд аврагч, аврах ажиллагаа, сургалт гэсэн хоршоо үгийн утгыг авч үзэх нь зүйтэй юм.

“**Аврагч**” гэдэг үгийг “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д “1. Ачтан тустны хүндэтгэл, аврах хүн; 2. Бурханы хүндэтгэл; 3. Авардаг юм” 21 дүгээр талд бичжээ.⁴³ Монгол Улсын Гамшаас хамгаалах тухай хуульд “**аврагч**” гэж аврах ажиллагааны арга технологийг эзэмшиж, мэргэжлийнхээ дагуу онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага,

⁴⁰ Мөн тэнд, х 8

⁴¹ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.15-д

⁴² Я.Цэдэв., Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, УБ., 1966, 19 дүгээр тал

⁴³ Я.Цэдэв., Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, УБ., 1966, 21 дүгээр тал

аврах болон мэргэжлийн ангид ажиллаж байгаа мэргэшсэн албан хаагчийг хэлнэ гэсэн байна.⁴⁴

Харин олон улсад “аврагч” гэдэг бол зохих бэлтгэл хангасан эрэл хайгуул, аврах болон бусад хойшлуулшгүй ажлыг гүйцэтгэгч орон нутгийн болон албадын мэргэжлийн анги ба салбарын албан тушаалтан⁴⁵ гэдэг утгаар бичигдсэн байна. Энэ тодорхойлолтоос үзвэл, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгий байгууллага, аврах болон мэргэжлийн ангид ажиллаж мэргэшсэн офицер, ахлагч нарыг хамруулан ойлгож байна. Онцгой байдлын албаны сургалтад бэлтгэл гэдгийг аюулгүй байдлыг хангахад суралцах, өөрийгөө боловсруулах, бэлэн байх, урьдчилан хангах гэсэн утгыг агуулж байна. Дээрх гурван үгийн агуулгыг нэгтгэн дүгнэвэл, аврагчдын сургалт бэлтгэл гэдэг ухагдахууныг дараах байдлаар тодорхойлж болох юм.

Аврагчдын сургалт бэлтгэл: гамшиг, олсын аюулаас иргэд, эд хөрөнгө, үнэт зүйлсийг эрэн хайх, аврах, нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх, аюулын хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үүргийг биелүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар, дадлыг албан сургалтаар олгож, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг бие бүрэлдэхүүнд эзэмшүүлж буй цогц үйл ажиллагаа гэж тодорхойлж болно.

Хүний амь аврах сургалт бол аврагч хүний үндсэн хөдөлмөр бөгөөд хүний амь нас, эд хөрөнгийг аврах бэлэн байдлыг хангах үндэс юм. Аврагчдын сургалт бэлтгэлийн мөн чанар нь сургалтын зорилго, зорилтууд, агуулга хэм хэмжээ, арга технологи, тэдгээрийн үр дүнд бүтээгдэх дадлага сургалтын чанар, үр дүн, аврах ажиллагааны ур чадвар, алба хаагчдын сэтгэл зүй, бие бялдар, багаар ажиллах нэгдсэн ажиллагаагаар илэрхийлэгдэнэ. Аврагчдын сургалт бэлтгэлийн зорилго нь Онцгой байдлын албаны аврах ажиллагааны үүрэг гүйцэтгэх бэлтгэл, бэлэн байдлыг хангахад чиглэгдсэн байна.

Сургалт бэлтгэл нь Онцгой байдлын албан хаагчдын хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, ард иргэдээ гал түймрийн болон гамшиг ослын голомтоос авран хамгаалахад шаардагдах, мэдлэг, чадвар, дадал болон багаар ажиллах нэгдсэн ажиллагаа, захирах захирагдах ёс улмаар сэтгэл зүй, бие бялдар, мэргэжлийн ур чадварыг суулгах зорилготой сургалт бөгөөд салаа, тасаг, хэсэг, бүлгийн даргалах бүрэлдэхүүнд аврах, гал унтраах үйл ажиллагааны шаталсан сургалт боловсрол олгох, иргэдэд гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх анхан шатны мэдлэг, дадлага эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.

⁴⁴ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.17-д

⁴⁵ Чөлөөт нэвтэрхий толь — Википедиагаас

Онцгой байдлын албан хаагчийн бие бялдарын чадамж (ББЧ)-ийг үнэлэх арга зүй

Энэ үзүүлэлт (тэсвэр, хурд, авхаалж самбаа, уян хатан)-үүд дэх авхаалж самбаа, уян хатан чанарыг шалгах дасгал, үзүүлэлтийг тодотгож өөрчлөх, хөдөлгөөний эвсэлийг шалгах, үнэлэх үзүүлэлтийг нэмж оруулбал бодит үнэлгээнд ойртоно. Онцгой байдлын албан хаагч (ОБАХ)-ийн бие бялдарын бэлтгэлжилтийг үнэлэх өнөөгийн үзүүлэлт (тэсвэр, хурд, авхаалж самбаа, уян хатан)-үүдийн нормативт тоон утгыг үсгэн үнэлгээгээр дүгнэж байгааг ОБАХ-ийн бие бялдарын чадварын үнэлгээ болгохын тулд тоон, эсвэл хувьчилсан (процентон) үнэлгээнд шилжүүлэх шаардлагатай. Энэ нь ОБАХ-ийн чадамжийг үнэлэх бусад үнэлгээний объектын үзүүлэлтийн үнэлгээ, дүгнэлттэй нэгтгэхэд нэг хэмжүүр тогтоох шаардлагаас урган гарч байгаа болно. Хэрвээ тэсвэр (Т), хурд (Х), авхаалж самбаа (А), уян хатан (У), хөдөлгөөний эвсэл (Э), хүч (Ү) гэж тэмдэглэвэл, ОБАХ-ийн бие бялдарын чадамж (ББЧ) нь:

$$\text{ББЧ} = (Т + Ху + А + У + Э + Хү) = В \text{ оноо}$$

Жишээ нь: тухайн ОБАХ нь Т=95; Ху=88; А=90; У=85; Э=70; Хү=86 гэсэн үнэлгээг тус бүрд нь авсан бол энэ нь:

$$\text{ББЧ} = (Т + Ху + А + У + Э + Хү) = (95 + 88 + 90 + 85 + 70 + 86) = 85,7$$

ББЧ нь 85,7 оноогоор үнэлэгдэж байна. Энэ нь үсгэн “В”, чанарын “сайн” үнэлгээтэй тэнцэж байна гэсэн үг. Эдгээр онооны үзүүлэлтийг бие бялдар шалгадаг ОБАХ-ийн нормативаар шалгаж авна.

Дүгнэлт

Онцгой байдлын албаны чанар төвшин, үр дүн нь тухайн албыг биечлэн гүйцэтгэж байгаа төрөл мэргэжлийн аврагчдын сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэл, түүнийг удирдан зохион байгуулдаг захирагч, дарга нарын ажлын арга барилаас шууд хамааралтай тул аврагч нэг бүрийн зан төлөв, сэтгэл зүйн онцлог, бие бялдар, ур чадварыг онол практикын хувьд сайн мэдэхгүйгээр тэднийг онцгой байдлын албаны үйл ажиллагаанд бэлтгэх асуудлыг шийдвэрлэх боломжгүй юм.

Аврагчдын сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэлд нөлөөлөх гэдэг нь хэрэгцээ шаардлага гарч тулгамдсан нөхцөл байдал үүссэн үед албан үүргийнхээ дагуу үйл ажиллагаа явуулахдаа эх орон, ард түмнээ гэсэн бат итгэл үнэмшилтэй, хууль эрх, зүйн мэргэжлийн өндөр мэдлэгтэй, мэргэжлийн алдаа эндэлгүй чадварлаг ажиллаж, цаг агаарын ямарч тохиолдолд оюун санаа бие бялдарын өндөр ачааллыг давж чадах сэтгэцийн тогтвортой чанарыг бие бүрэлдэхүүнд төлөвшүүлэх тухай асуудал юм. Өөрөөр хэлбэл төрөл мэргэжлийн аврагчдын албан үүрэг гүйцэтгэх явцад учирч болзошгүй аюул занал, бэрхшээл саадыг даван

туулах тэдний сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын нэг цогц үнэлгээ гэж ойлгож болно. Аюул занал гэдэг нь удаан хугацаагаар үргэлжилсэн томоохон хэмжээний объектын болон ой хээрийн гал түймрийг унтраах болон аврах үйл ажиллагаанд оролцох, бусад гамшиг ослын голомтод үүрэг гүйцэтгэж яваад амь нас эрсдэж болзошгүйд хамруулан ойлгож болно. Харин бэрхшээл саад гэдэгт байгалийн гамшигт үзэгдэл \цасан болон шороон шуурга, хүчтэй аадар бороо, аянга цахилгаан, үер, химийн хортой бодис алдагдах, хүн, малын гоц халдварт өвчин гэх мэт\ сэтгэл санааны хямралд орох явдал юм.

Сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын гурвалсан сургалт бэлтгэлийн удирдлагын үндсийг менежментийн онолд мотиваци гэж үздэг бөгөөд энэ нь хүмүүсийг ямар нэгэн зүйлд анхаарлыг нь татах, сонирхол төрүүлэх, хүсэл өдөөх, нөлөөлөхийг мотиваци гэж тодорхойлсон байдаг. Орчин үеийн менежментийн онолын сэтгэл зүйг зөв удирдлага болох мотивацийн үр нөлөөг зөв тогтоон ажилласан удирдлага, даргалах бүрэлдэхүүн, анги байгууллагадаа дараах давуу талуудыг бий болгож чадна гэж эрдэмтэн судлаачид үзэж байгаатай санал нэг байна. Үүнд:

- Харилцан итгэл хүлээсэн, багаар ажиллах чадвартай шилдэг хүний нөөц, салаа, бүлэг, тасгийг бүрдүүлэх;
- Хамт олон ажлын байр, ажил албаараа бахархах, нэр хүндийг өргөх, албаа гэсэн сэтгэлтэй, таатай уур амьсгал бий болгох;
- Сэтгэл хоёрдолгүй, тогтвортой үр бүтээлтэй ажиллах хүсэл сонирхол бүрдэж, айж эмээх, цочирдох, сэтгэл санааны хямралд өртөх зэрэг сөрөг хүчин зүйлээс сэргийлэх сэтгэлийн хатуужилтай болсон байх;

Бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэл нь эдгээр бүх чиглэлүүдээр аврагчдын сургалт, судалгааны ажилд иж бүрэн хандсан нөхцөлд амжилттай хэрэгжинэ. Аврагчдын сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэлийг дээшлүүлж, ямарч бэрхшээлийг даван туулахад бэлэн байх чадварыг төлөвшүүлэхэд төрөл мэргэжлийн аврагчдын хамт олны нөхөрлөл, бие биедээ туслах, бие биенээ орлон ажилладаг хамт олонч чанар идэвхитэй нөлөө үзүүлдэг.

Бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэлийг дээшлүүлэх бас нэг чухал чиглэл нь даргалах бүрэлдэхүүнийг сургах, тэдний онол практикийн мэдлэг, чадвар, туршлага, хүнтэй ажиллах арга барилаас ихээхэн шалтгаалдаг.

Ашигласан материал

Нэг. Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992.
2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010.
3. Гамшгаас хамгаалах тухай хууль.
4. Гал түймэр унтраах дүрэм. УБ.
5. Гал түймрийн аюулаас хамгаалах аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм. MNS 5566:2005 стандарт.
6. Гал унтраах ангийн хэрэглэл, галын автомашины тоо, MNS 5108:2001 стандарт. УБ., 2001.
7. Т.Лхамжав., Гал унтраах сэтгэл зүйн бэлтгэл. Улаанбаатар., 2001.
8. О.Ганхуяг., Гал унтраах мэргэжлийн сургалтын сурах бичиг. Улаанбаатар., 2012.
9. П.Цэдэв., Аврагчдын бэлтгэл. Улаанбаатар., 2007.
10. П.Цэдэв., Аврагчдын сэтгэл зүйн бэлтгэл, түүнд тавигдах шаардлага сургалтын материал. Улаанбаатар., 2010.